

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.70

Хувийн хөвөгч хэрэгсэл. 5-р хэсэг: Хөвүүлэгч хэрэгсэл (түвшин 50). Аюулгүй ажиллагааны шаардлага	MNS ISO 12402-5 : 2017
Personal flotation devices-part 5: Buoyancy aids (level 50) – safety requirement	ISO 12402-5 : 2006

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 55 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

ISO 12402 стандартын энэхүү бүлэгт хэрэглэгчийн хөдөлгөөнийг хязгаарлаж болзошгүй овор ихтэй хөвөгч хэрэгслийг хамгаалагдсан усанд хэрэглэх боломжгүй нөхцөлд түүний гараас татаж аврах, туслахад хэрэглэх 50N-оос багагүй хөвөх чанартай хөвүүлэгч хэрэгслийн аюулгүйн ажиллагаанд тавих шаардлагыг тодорхойлсон. Энэ нь насанд хүрэгчид болон хүүхдүүд хэрэглэхэд зориулсан хөвүүлэгч хэрэгсэлд хамаарна.

2 Норматив эшлэл

Дараах жишиг баримт бичиг нь энэхүү баримт бичгийн салшгүй хэсэг мөн. Хугацаатай жишиг баримтын хувьд иш татсан хувилбарыг оруулав. Хугацаагүй баримт бичгийн хувьд хамгийн сүүлд боловсруулсан хувилбарыг нэмэлт өөрчлөлтийн хамт оруулав.

ISO 12402-7:2006 стандарт, *хувийн хөвөгч хэрэгсэл —7-р хэсэг: Хөвүүлэгч хэрэгслийн материал ба загвар — Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага ба турших, шалгах арга*

ISO 12402-8:2006 стандарт, *хувийн хөвөгч хэрэгсэл - 8-р хэсэг: Дагалдах хэрэгсэл — Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага ба турших, шалгах арга*

ISO 12402-9:2006 стандарт, *хувийн хөвөгч хэрэгсэл - 9-р хэсэг: Турших, шалгах арга*

ОУДБ-ын А.658 (16) тогтоол, *аврах хэрэгсэл дээрх гэрэл ойлгогч материалыг ашиглах, тохируулах*, Олон Улсын Далайн Байгууллага¹⁾

3 Нэр томъёоны тайлбар

Энэхүү баримт бичгийн зорилгод дор дурдсан нэр томъёог хэрэглэсэн болно.

3.1

Хувийн хөвөгч хэрэгсэл (цаашид “ХХХ” гэх)

Усан орчинд, хэрэглэгчийг усан дээр тодорхой хугацаанд хөвүүлэхэд зориулагдсан, зөв өмсөж хэрэглэсэн тохиолдолд амь насны баталгааг нь хангаж буй хувийн хамгаалалтын өмсгөл буюу хэрэгсэл.

3.2

Усанд хөвөгч материал

Нягтаршил нь усны нягтаас ямагт бага байх материал.

3.3

Автомат ажиллагаатай ХХХ

Зөв өмссөн тохиолдолд хэрэглэгчийн зүгээс үйлдэл хийхийг шаардахгүй, байнгын хөвүүлэх чадвар /нягтаршил нь усны нягтаас бага материал/-тай буюу усанд хүрмэгц автоматаар идэвхждэг /даралтат хийн/ системтэй, үзлэг хяналт, засвар өөрчлөлт хийгдсэн хийлдэг төрлийн хөвүүлэгч хэрэгслээс бусад хувийн хөвөгч хэрэгсэл.

3.4

Автоматаар хийлэгддэг ХХХ

Усанд хүрмэгц хэрэглэгчийн оролцоогүйгээр хийлэгддэг хувийн хөвөгч хэрэгсэл.

3.5

Гараар хийлдэг ХХХ

Хэрэглэгч, хийлэгч шахуургаар хийлдэг хувийн хөвөгч хэрэгсэл.

3.6

Амаар хийлдэг ХХХ

Хөвүүлэхийн тулд амаараа хийлдэг хувийн хөвөгч хэрэгсэл.

3.7

Нэмэлт өмсгөлтэй ХХХ

Хэрэглэгч ердийн үед байнга өмсөх хөвөгч хэрэгслийг өөр илүү хүнд бэрх үйл ажиллагаа гүйцэтгэх үедээ нэмэлт өмсгөл өмсөх, тохируулга хийхийг шаарддаг хувийн хөвөгч хэрэгсэл.

ТАЙЛБАР: Уутан хэлбэртэй хөвөгч хэрэгсэл нь нэмэлт өмсгөл шаарддаг ХХХ-ийн жишээ бөгөөд уг ХХХ нь ихэнхдээ нэмэлт тохируулга шаарддаг.

3.8

Хантааз хэлбэрийн ХХХ

Хэрэглэгчийн цээжин биед өмсөх зориулалттай хантааз хэлбэрийн хувийн хөвөгч хэрэгсэл.

3.9

Хүзүүвч хэлбэрийн ХХХ

Хүзүүндээ углаж, бэлхүүсээрээ бэхэлдэг хувийн хөвөгч хэрэгсэл.

3.10

Ослын дохионы гэрэл

Хэрэглэгчийн байршлын өөрчлөлтийг тогтоох боломжийг нэмэгдүүлж буй гэрлийн үүсгүүр.

3.11

Олон тасалгаат хөвүүлэгч

Хөвөх чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор хийлдэг аврах хантаазыг хоорондоо тусгаарлагдсан хоёр ба түүнээс олон тасалгаанд хуваасан систем. Хэрэв аль

нэгэн тасалгаанд механик гэмтэл гарвал үлдсэн хэсэг нь хэвийн ажиллах бөгөөд живж буй хэрэглэгчийг хөвөхөд тусална.

3.12

Тавцангийн аюулгүй байдлын бэхэлгээ ба хашлаганы аюулгүйн бүс

Хэрэглэгч ус руу унахаас, унасан тохиолдолд хөлөг онгоц болон эргээс холдохоос урьдчилан сэргийлж, түүний аюулгүй байдлыг ханган хөлөг онгоц болон эргээс сайтар бэхэлсэн хэрэгсэл.

3.13

Холбогч олс

Хэрэглэгчийг өөр бусад хэрэглэгч болон түүний хөвөгч хэрэгсэлтэй, эсвэл бусад объектоос аргамжиж бэхэлсэн урт олс. Энэ нь тухайн хэрэглэгчийг холбосон объект болон өөр бусад хэрэглэгчийн ойр орчимд тогтоон барьж, байршлыг нь тодорхойлон аврах ажиллагааг түргэн шуурхай үзүүлэхэд тус дөхөмтэй.

3.14

Өргөгч гогцоо

Хэрэглэгчийг уснаас татаж гаргах гар ажиллагааг хөнгөвчилж буй хэрэгсэл.

3.15

Давалгааны хаалт

Хэрэглэгчийн урд байрлуулан хүчтэй урсгал, давлагаа, долгиогоор үүсч цацарсан усыг багасган хааж, амьсгалын замыг нь чөлөөлж хүчтэй урсгал, давалгаа, долгиотой уснаас амьд гарах боломжийг нь нэмэгдүүлэх хаалт.

3.16

Хамгаалах хучлага

Хувийн хөвөгч хэрэгслийн ажиллагааны хэсгийг урагдаж, эвдрэх болон гаднын объектод өртөхөөс хамгаалж хучдаг хучлага.

ТАЙЛБАР 1. Хамгаалах хучлага нь нэмэлт дагалдах хэрэгслийн зориулалттай бөгөөд ХХХ-ийг үрэгдэж цоорох, гагнуурын оч үсрэн түлэх, галд шатах зэрэг гаднын нөлөөнөөс хамгаалж, хэрэглэхэд тохиромжтой.

ТАЙЛБАР 2. Хийлдэг ХХХ-ийн хийлдэг тасалгаа нь үйл ажиллагаа гүйцэтгэх элементийн жишээ мөн.

3.17

Хийн хэт даралтаас хамгаалах хавхлага

Хийлдэг систем, хөвүүлэгч хэрэгслийг хэт хийлж хагалах, эвдэхээс урьдчилан сэргийлэх зориулалттай хавхлага.

3.18

Шүгэл

Хэрэглэгч амаараа үлээж дуу чимээ гарган байршлаа мэдэгдэхэд зориулагдсан хэрэгсэл.

3.19

Хосолмол ажиллагаатай ХХХ

Хийлдэг болон өөрөө хөвөгч чанартай зэрэг холимог хөвүүлэгчтэй хувийн хөвөгч хэрэгсэл.

4. Ангилал

4.1 Анги

4.1.1 Аврах хантааз

Эдгээр ХХХ нь хэрэглэгчийн нүүрийг усны мандалд дээш нь харуулан зохих түвшинд хөвүүлэхэд зориулагдсан, задгай далайд болон ширүүн урсгал, давалгаатай усанд ашиглана. Аврах хантааз нь ихэнх хэрэглэгчийг дээш нь эргүүлэн харуулах чадвартай жигд тархсан хангалттай хөвүүлэгчтэй байх ба ISO 12402 стандартын дагуу түүнийг усны хувцас өмссөн хэрэглэгч дээр туршихад хэрэглэгчийн ам, хамрыг усны мандлаас дээш тодорхой түвшинд барьж байх бөгөөд хэрэглэгч ухаан алдсан үед ч мөн ийм байрлалд байрлуулна.

4.1.2 Хөвүүлэгч хэрэгсэл

Эдгээр хөвүүлэгч хэрэгсэл нь байнга өмсөхөд эвтэйхэн, усны мандалд дээш харж хэвтэх чадвар шаардахгүй, хэрэглэгчийг дээш өргөж, түүнд заасан зааврын дагуу хөвүүлэхэд зориулагдсан. Хөвүүлэгч хэрэгслийг хамгаалалттай усанд хэрэглэхэд тохиромжтой, бусад тохиолдолд өндөр түвшинд хэрэглэж болно.

4.1.3 Тусгай зориулалтын аврах хантааз ба хөвүүлэгч хэрэгсэл

Эдгээр хэрэгсэл нь 4.1.1 ба 4.1.2-т заасантай ижил үүргийг дэмжиж өөр өөр түвшинд гүйцэтгэх боловч хэрэглээний тусгай зориулалтаас шалтгаалан тухай бүр өөрчилж хэрэглэнэ. Энэхүү өөрчлөлт нь тэдгээр хэрэгслийн усан доторх ашиглалт, тогтвортой болон аюулгүй байдлыг хангахад тавигддаг үндсэн шаардлагыг хөндөх ёсгүй. Ашиглалтын онцгой нөхцөл шаардлагыг баримтлах бол хэрэглээний тусгай нөхцөлийг шошгон дээр нь заана.

4.2 ХХХ-ийн гүйцэтгэлийн түвшний ангилал

4.2.1 Гүйцэтгэлийн түвшин 275

Энэ түвшний ХХХ нь эргээс хол далай тэнгисийн усанд үнэмлэхүй онцгой хүнд нөхцөл байдалд хэрэглэгдэнэ. Ус, агаар нэвтрүүлж хөөж бөмбийн, аврах хантааз өмсөхөд саад болж болзошгүй хувцас өмссөн хэрэглэгчдэд илүү тохиромжтой. Хэрэглэгчийг ам, хамраа уснаас ил гарган, зөв байрлалд сэлж сургахад зориулсан.

4.2.2 Гүйцэтгэлийн түвшин 150

Энэ түвшний ХХХ нь цаг агаарын ердийн ба таагүй нөхцөлд нийтлэг хэрэглэхэд зориулагдсан. Энэ түвшний ХХХ ухаан алдсан хэрэглэгчийг усан дотор нүүрийг дээш харуулан эргүүлж, аюулгүй байрлалд байрлуулах ба хэрэглэгчийг энэхүү байрлалд тогтоон барьж, түүнээс илүү хөдөлгөөн шаарддаггүй.

4.2.3 Гүйцэтгэлийн түвшин 100

Энэ түвшний ХХХ нь хамгаалалттай усанд аврах ажиллагаа хүлээж буй буюу хүлээх шаардлагатай байгаа хэрэглэгчдэд зориулагдсан. Уг ХХХ-ийг цаг агаарын хүнд нөхцөл, ширүүн урсгал, давалгаатай хэрэглэхийг хориглоно.

4.2.4 Гүйцэтгэлийн түвшин 50

Энэ түвшний ХХХ нь усанд чадварлаг сэлэгчид, мөн гол, мөрөн, тэнгис, далайн эрэг, хад чулууны ойролцоо ажиллаж, аялж, амарч байгаа болон ямар нэгэн тусламж үзүүлэх, авах боломжтой хөвүүлэгч хэрэгслийг гарын дор ойрхон байлгаж буй хэрэглэгчдэд зориулагдсан. Эдгээр өмсгөл нь овор багатай хэдий ч цаг агаарын хүнд нөхцөл, ширүүн урсгал, давалгаатай нөхцөлд хэрэглэгдэхгүй, хэрэглэгчийн аюулгүй байдлыг удаан хугацаагаар хамгаалах боломжгүй хийгдсэн байдаг. Өөрийгөө аврах чадваргүй, туршлагагүй хүмүүс хэрэглэхэд хөвүүлэх чанар нь хангалтгүй, хэрэглэгчээс идэвхтэй оролцоо, хөдөлгөөн шаарддаг.

5 Тавих шаардлага

5.1 Ерөнхий зүйл

Хөвүүлэгч хэрэгсэл нь ISO 12402-9 стандартын дагуу хийсэн туршилтын 5-р зүйлд тодорхойлсон шаардлагыг хангасан байна.

Хөвүүлэгч хэрэгсэлд ашиглах материал, бүрдүүлэгч хэсгүүдийг ISO 12402-7:2006 стандартын 4.1.6.4-т зааснаас бусад нь ISO 12402-7 стандартад нийцсэн байна.

ISO 12402 стандартын энэ хэсэгт нийцсэн хийлдэг хөвүүлэгч хэрэгсэл нь автомат эсвэл гар ажиллагаагаар хийлэгддэг байх ба тэдгээр нь ISO 12402 стандартын энэ хэсэгт заасан ашиглалтын бүх шаардлагад бүрэн хангаж байна. Хийлдэг хөвүүлэгч хэрэгслийн тасалгаа бүр нэмэлт амаар хийлэгчтэй байх ёстой.

Хийлдэг хөвүүлэгч хэрэгслийн тасалгаа нэг бүр нь гар ажиллагаагаар болон амаар хийлдэг байна. Хийлдэг хөвүүлэгч хэрэгслийн дурын нэг тасалгаа хийгүй болсон байхад ч ISO 12402 стандартын энэхүү хэсэгт заасан ашиглалтын шаардлагыг хангаж байна. Хийлдэг хөвүүлэгч хэрэгслийг ISO 12402-7:2006, 4.11 ба ISO 12402-9:2006, 5.5.11 стандартад заасны дагуу тохиолдлоор сонгож хийлэхгүйгээр туршина.

5.2 Хөвүүлэгч хэрэгсэл, түүний дагалдах хэрэгслийг хослуулах

5.2.1 Ерөнхий зүйл

Хөвүүлэгч хэрэгсэлд ашиглах дагалдах хэрэгслийг ISO 12402-8 стандартын Хүснэлт 1-д тодорхойлсны дагуу сонгоно.

Хөвүүлэгч хэрэгсэл, түүний дагалдах хэрэгслийг хослуулах нь түүний ашиглалтын чанар, аливаа нэг элементэд сөргөөр нөлөөлөхгүй. Үүнийг хөвүүлэгч хэрэгсэл, түүний дагалдах хэрэгсэлд шаардлагатай туршилт хийснээр баталгаажуулна. Шаардлагатай бол туршилтын дарааллыг зохих ёсоор төлөвлөж гүйцэтгэнэ.

1-р хүснэгт - Хөвүүлэгч хэрэгслийн дагалдах хэрэгсэл

Дагалдах хэрэгсэл	Заавал байх ёстой (М) / Нэмэлт (О)
Ослын дохионы гэрэл	О
Шүгэл	О
Өргөгч гогцоо	О

MNS ISO 12402-5 : 2017

Холбогч олс	О
Гэрэл ойлгогч материал	О
Тавцангийн аюулгүй байдлын бэхэлгээ, хашлаганы аюулгүй бүс	О
Хийн хэт даралтаас хамгаалах хавхлага	О
Олон тасалгаат хөвүүлэгч систем	О
Хамгаалах хучлага	О
Давалгааны хаалт	О

Хөвүүлэгч хэрэгслийг цаашид нэмэлт тоноглол, хэрэгслээр тоноглож болох ба эдгээр тоноглол хэрэгслийг ISO 12402-8 стандартад нийцүүлэн сонгоно.

5.2.2 Өргөгч гогцоо

Хэрэв хөвүүлэгч хэрэгсэл нь өргөгч гогцоотой бол түүнийг ISO 12402-9:2006, 5.5.1.4 стандартыг баримтлан туршина.

Өргөгч гогцоог хөвүүлэгч хэрэгслийн цээжний өмнө талын хоёр шугамаар тэнхлэгийн шугамын дагуу өвчүү буюу өрцний төгсгөлд хүйснээс дээш 100 мм-ээс багагүй зайд бэхэлнэ.

Гогцоо нь 150 мм-ээс багагүй урттай байх ба гогцооны төгсгөлөөс бэхэлгээ хүртэл хэмжигдэнэ.

Өргөгч гогцоо нь 20 мм-ээс багагүй өргөнтэй байх ба хөвүүлэгч хэрэгслээс тод ялгагдах өнгөтэй байна.¹

Хэрэглэгч хэвийн байдлаар хөвж байгаа үед өргөгч гогцоо нь ил тод харагдахуйц байх ёстой.

5.5 дугаар заалтыг харах

5.2.3 Шүгэл

Хөвүүлэгч хэрэгсэл шүглээр тоноглогдсон байж болно. Шүгэл нь ISO 12402-9:2006, 5.5.1.4 стандартад нийцсэн байна.

5.2.4 Давалгааны хаалт

Давалгаа, долгионоос хамгаалах юүдэн болон шүршүүр юүдэн хэлбэрийн дурын хаалт нь хэрэглэгчийн нүүрийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хаах ёстой бөгөөд ISO 12402-8:2006, стандартын 5.5-д заасан шаардлагыг хангасан байна.

5.3 Хөвүүлэгчийн төрөл

5.3.1 Ерөнхий зүйл

³⁾ Нийтлэгдсэн

⁴⁾ Нийтлэгдсэн

5.3.1.1 Хөвүүлэгчийн хөвүүлэх нийлбэр чадвар нь ISO 12402 стандартын энэхүү хэсэгт заасан усан доторх ашиглалтын шаардлагыг хангаж байна. (хөвөгч хавтан, тогтвортой хөвөх байрлал г.м)

Хөвүүлэгч хэрэгсэлд ашиглах хөвүүлэгчийн хөвүүлэх чадварын хамгийн бага нийлбэрийг 2-р Хүснэгтэд тодорхойлсон бөгөөд усанд хөвөгч чанартай материал, даралтат хийгээр хийлэгддэг тасалгаа, эсвэл эдгээрийг хослуулан хэрэглэж болно.

5.3.1.2 Хөвүүлэгч хэрэгсэл нь хосолмол ажиллагаатай төрлийнх бол уг хэрэгсэл усанд дангаараа хөвөх чадвартай ч өөрийн хөвөх чадвараар (50) түвшний хөвүүлэгч хэрэгсэлтэй тэнцүү хэмжээний хөвөлтийн шаардлага хангасан байна.

5.3.2 Хийлдэг тасалгаат хөвүүлэгч

5.3.2.1 Хийлдэг тасалгаат хөвүүлэгч нь ISO 12402-9:2006 стандартын 5.5.6-д заасны дагуу -5°C ба $+30^{\circ}\text{C}$ -ийн температурт 2 минутын туршилтад оруулахад элдэв гэмтэл, хэлбэрийн гажилтгүй, 70кПа дотоод даралтыг тэсвэрлэх чадвартай байна.

Хийлдэг тасалгаат хөвүүлэгч хэрэгсэл нь хийн хэт даралтаас хамгаалах хавхлагатай ажиллаж байвал хавхлагыг хааж, ISO 12402-9: 2006 стандартын 5.5.6-д заасны дагуу 40 кПа-ийн туршилтад оруулна.

5.3.2.2 Хий /газ/-гээр - хийлдэг хөвүүлэгч хэрэгсэл ISO 12402-9:2006 стандартын 5.5.10-д заасан хийн туршилтыг тэсвэрлэх чадвартай байх ба хөвүүлэгч хэрэгслийг туршихын өмнө түүний хөвөх чадварын туршилтыг ISO 12402-9:2006 стандартын 5.5.9-д заасны дагуу гүйцэтгэнэ. Усанд унаснаас хойш автомат горимоор хийлэгдэх хүртэл хугацаа нь 5 секундээс хэтрэхгүй байна.

5.3.3 Усанд хөвөгч материал

5.3.3.1 Хөвүүлэх зорилгоор ашиглаж буй хөвөгч чанартай дурын материал нь хөвөх чанараа алдахгүй, ямар нэгэн дэмжлэггүйгээр байнга тогтвортой байлгаж, даралтад тэсвэртэй байх ба хэвийн ашиглалтын нөхцөлд өмссөн үед хөдөлгөөний элэгдлийг дааж байх ёстой.

5.3.3.2 Хөвөгч чанартай дурын материалын шинж чанарыг ISO 12402-7:2006 стандартын 4.8-д заасны дагуу батална.

5.3.4 Нийт хөвөх чадвар

5.3.4.1 ISO 12402 стандартын энэ хэсгийн дагуу үнэлгээ хийх зорилгоор, өөр өөр хэмжээтэй хөвүүлэгч хэрэгсэлд хэрэглэгчийн хамгийн их ба хамгийн бага жинг заах бөгөөд тэдгээр нь тэмдэглэгдсэн хэмжээсийн хязгаарт нийцэж байна.

Хөвүүлэгч хэрэгслийн хэмжээ тохирч буй эсэхийг зааж буй үндсэн заалт нь нэг байх ба бодит хэрэглэгчийн хувьд чухал ач холбогдолтой, тохиромжтой байх ёстой, тухайлбал, цээжний тойрог, жингийн хязгаар г.м.

5.3.4.2 ISO 12402-9:2006 стандартын 5.5.9-д заасны дагуу туршилт хийх үед өөр өөр түвшний хөвөх хамгийн бага чадвар нь 2-р хүснэгтэд заасантай нийцэж байх

ёстой.

2-р хүснэгт - Хөвөх хамгийн бага чанар

Үзүүлэлт	Хэрэглэгч				
	Хүүхэд	Насанд хүрэгч			
Хэрэглэгчийн жин, <i>m</i> (кг)	25 < <i>m</i> ≤ 40	40 < <i>m</i> ≤ 50	50 < <i>m</i> ≤ 60	60 < <i>m</i> ≤ 70	<i>m</i> > 70
Хөвөх хамгийн бага чанар (N)	35	40	40	45	50

5.3.4.3 Хөвүүлэгч хэрэгсэл нь хоёр ба түүнээс олон жингийн ангилалд зориулагдсан бол хөвөх чадвар нь доод тал нь хүнд жингийн ангилалд тохирсон байх ёстой.

5.3.4.4 Хөвүүлэгч хэрэгслийн хөвөх чадварыг ISO12402-9:2006 стандартын 5.5.9-д заасны дагуу туршиж шалгана. Анхны хэмжилт болон 24 цаг өнгөрсний дараах хэмжилт хоорондын зөрүү нь жинхэнэ хөвөх чадварын 5%-иас хэтрэхгүй байна.

Хөвөх чадварын хэмжээ ISO12402 стандартын энэхүү хэсэгт нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд хийсэн аливаа туршилтаар, хөвүүлэгч хэрэгсэл дээр тамгалсан тэмдэглэгээнээс багагүй буюу 5.3.4.2-т шаардсанаас багагүй байна.

5.3.4.5 ISO12402-9:2006 стандартын 5.5.9-д заасны дагуу туршилтад хамрагдсан хоёр хөвүүлэгч хэрэгслийн хөвөх чадварын хэмжээг нийт хөвөх чадварыг хэмжихэд хэрэглэнэ.

5.4 Гэрэл ойлгох чанар

5.4.1 Өнгө

Хөвүүлэгч хэрэгсэл дурын буюу олон өнгөтэй байж болно.

5.4.2 Гэрэл ойлгогч материал

Уснаас аврах ажиллагаанд шаардагдах тохиолдолд хөвүүлэгч хэрэгслийн гадаргуу дээр 100см² –аас багагүй хэмжээтэй гэрэл ойлгогч материалыг хадаж бөхлөх ба тус материал нь Олон улсын далайн байгууллагын A.658 (16) шийдвэрийн 2-р Хавсралтад тодорхойлсонтой нийцэж байна.

Усан дотор тайван байдалд байгаа хэрэглэгчийг хөвөхөд дэмжлэг үзүүлэх үед ойролцоогоор дээр дурдсан хэмжээний материал эргэн тойрны бүх чиглэлээс харагдах ёстой ба хөвүүлэгч хэрэгсэл болон гэрэл ойлгогч материал нь усны түвшнээс дээш байрласан байна.

Хоёр талаар нь өмсөх боломжтой хөвүүлэгч хэрэгслийг аль ч талаар нь өмссөнөөс үл хамааран хамгийн бага зай эзлэх иж бүрдлээр хангагдсан байна.

5.5 Бэхэлгээ

Хөвүүлэгч хэрэгслийн бэхэлгээг ISO 12402-9: 2006 стандартын 5.5.1-д заасны дагуу туршина. ISO 12402 стандартын энэ хэсэгт заасны дагуу хөвүүлэгч хэрэгслийг хэвийн ажиллах боломжгүй болгох гэмтэл, эвдрэлгүй байх ёстой.

Бэхэлгээнд туршилт хийх үед тохируулгын гулсалт нь 25мм-ээс хэтрэхгүй байна.

Хэвтээ ачаалал нь насанд хүрэгчид болон хүүхдэд 2000N-ээс багагүй байна. Босоо ачаалал нь насанд хүрэгчид болон хүүхдийн хувьд 750N-аас багагүй байна.

Өргөгч гогцоог ISO 12402-9: 2006 стандартын 5.5.1.4-т заасны дагуу турших шаардлагатай бол хэвтээ ачааллын утгыг хэрэглэнэ. Хэрэв өөрөөр заагаагүй бол ачааллыг 5 минутын турш өгнө.

5.6 Гүйцэтгэл

5.6.1 Ерөнхий зүйл

5.6.1.1 Хөвүүлэгч хэрэгслийг өмссөн үед болон ISO 12402-9:2006 стандартын 5.5 ба 5.6-д нийцүүлэн өмсөж турших үед овор ихтэй, хүнд буюу эвгүй байх ёсгүй.

5.6.1.2 Хөвүүлэгч хэрэгсэл нь эрэг дээр болон усанд өмссөн үед ба ISO 12402-9:2006 стандартын 5.6-д нийцүүлэн өмсөж турших үед хэрэглэгчийн харах, сонсох, амьсгалах чадвар болон хөдөлгөөнийг ямар нэг байдлаар хязгаарлах ёсгүй. Энэ нь уяа, бэхэлгээг татаж чангалах, эсвэл сулруулах зэрэг шаардлагатай бүх тохируулгыг эрэг дээр болон усан дотор хялбар гүйцэтгэх боломж олгоно. Хөвүүлэгч хэрэгсэл нь усан дотор болон эрэг дээр өмссөн үед биед эвтэйхэн, орчныг харахад болон толгой, хөл гарын хөдөлгөөнд саад болохгүй байх ёстой ба аюул ослын үед усан дотор ч, эрэг дээр ч ашиглахад биед эвтэйхэн байх ба эвдрэл, гэмтлээс хамгаалагдсан байна.

5.6.1.3 Хөвүүлэгч хэрэгсэл нь хэвийн ашиглалтын үед хэрэглэгчид гэмтэл учруулах болон ISO 12402-9:2006 стандартын 5.5 ба 5.6-д нийцүүлэн хийсэн туршилтын үед хөвүүлэгч хэрэгслийг эвдэх, гэмтээж болзошгүй элдэв бүрдэл хэсгүүдтэй байх буюу тэдгээрийг бэхлэх аливаа арга хэрэгсэл ашиглах ёсгүй.

5.6.1.4 Хөвүүлэгч хэрэгсэл нь хурдан шалмаг хөдөлгөөнд аль болох саад болохооргүй байна. Хэрэглэгч хөвүүлэгч хэрэгслийг ашиглах үедээ сэлэх, шатаар өгсөх, зогсоол, тавцан дээр гарах чадвартай байх ба ISO12402-9:2006 стандартын 5.6-д заасны дагуу туршилт хийх үед хөвүүлэгч хэрэгслийн тусламжгүйгээр, мөн тухайн хөвүүлэгч хэрэгслийг усан дотор ашиглах чадвартай байна. Оролцогчын гуравны хоёроос доошгүй нь ISO 12402-9:2006 стандартын 5.6-д заасан даалгаврыг хөвүүлэгч хэрэгслийн тусламжгүйгээр гүйцэтгэж чадах бол хөвүүлэгч хэрэгслийн тусламжтайгаар бүрэн гүйцэтгэх боломжтой байх ёстой.

5.6.1.5 Хөвүүлэгч хэрэгсэл нь ашиглалт, хадгалалтын хэвийн нөхцөлд бүх шалгалт, сорилтыг тэсвэрлэх ёстой. Хөвүүлэгч хэрэгслийг ISO 12402-9:2006 стандартын 5.5 ба 5.6-д заасны дагуу туршилтад оруулсны дараа эвдрэл, гэмтэлгүй, ашиглах боломжтой байна.

5.6.1.6 Хөвүүлэгч хэрэгсэл нь хэрэглэгчийн толгой, нүүр лүү усыг шууд чиглүүлсэн суваг үүсгэхээргүй байна. Усанд туршилтын үйл ажиллагаа явагдах үед туршилтын тавцанд нүдээрээ хяналт тавина.

5.6.1.7 Автоматаар хийлэгддэг хөвүүлэгч хэрэгслийг ISO12402-9:2006 стандартын 5.5.11-д заасны дагуу тохиолдлоор сонгож, хийлэхгүйгээр туршина.

5.6.2 Өмсөх, тохируулах, тааруулах

5.6.2.1 Хөвүүлэгч хэрэгсэл нь яг таарч тохирсон, өмсөхөд хялбар байна. Ашиглалтад тохирсон шаардлагатай бэхэлгээ, хэлхээ холбоос нь цөөн, энгийн байх ёстой.

5.6.2.2 Өмсөлт нь энгийн хялбар, товч зааварчилгаатай байна. Хүүхдэд зориулснаас бусад хөвүүлэгч хэрэгслийг бусдын туслалцаагүйгээр өмсөх боломжтой байна. Хөвүүлэгч хэрэгсэл нь хүйтэн, нойтон, гэрэл муутай гэх мэт тааламжгүй нөхцөлд ашиглахад сөргөөр нөлөөлөхгүй, өмсөж тайлахад хялбар байна.

Хөвүүлэгч хэрэгслийн бүх тоноглол, бэхэлгээг хийж, аюулгүй байдлыг ханган өмсөж ISO 12402-9 стандартын дагуу турших үед усан доторх ашиглалтын шаардлагыг 1-ээс илүүгүй минутад биелүүлэх ёстой.

5.6.2.3 ISO 12402-9 стандартад нийцүүлэн туршилт хийх үед тохируулгын хэрэгслүүд нь заасан хэмжээнүүдийн хязгаарын дотор байх ба баталгаатай тохирсон байна. Тохирлын аюулгүй байдал нь материалын хэт уян хатан чанараас хамаарах ёсгүй.

Тохирлын аюулгүй байдлыг сайжруулах хэт уян хатан бус хэрэгсэл буюу хөл хоорондуур аарцгаар татах бэхэлгээ тохиромжтой бөгөөд түүнийг боломжтой бол (хөвүүлэгч хэрэгслийн эвдрэл, гэмтэлгүй үед) хөвүүлэгч хэрэгсэл дээр бэхэлгээ буюу хэрэгсэлгүйгээр өмсөж болох ба туршилтыг ISO 12402-9:2006 стандартын 5.6.4 ба 5.6.5-д заасны дагуу бэхэлгээ, эсвэл хэрэгсэлгүйгээр газар дээр нь хийнэ.

5.6.2.4 ISO 12402-9 стандартын дагуу турших үед хэрэглэгч нь хөвүүлэгч хэрэгслээс гулсаж сугаран гарах ёсгүй.

5.6.2.5 Гар шахуургаар болон амаар үлээж хийлдэг хөвүүлэгч хэрэгслийг усан дотор ба усны гадна талд ISO 12402-9:2006 стандартын 5.6.5 ба 5.6.7-д заасны дагуу туршина.

5.6.3 Усан доторх гүйцэтгэл

5.6.3.1 Хөвүүлэгч хэрэгсэл нь хэрэглэгчийн биеийг хажуу талаас нь эсхүл толгойн ар шилнээс дэмжиж тамир тэнхээгүй ядарсан үед түүний амыг усны гадаргуу дээр тогтоон барих үүрэгтэй ба ISO 12402-9:2006 стандартын 5.6-д заасантай нийцүүлэн турших үед их биеийг арагш нь босоо хэлбэртэй байрлуулна.

Бүх туршилтыг 6-аас доошгүй тооны хүмүүс дээр ISO 12402-9:2006 стандартын 5.6-д заасны дагуу цэвэр усанд хэвийн нөхцөлд гүйцэтгэнэ.

Туршилтад оролцогчид усанд сайн сэлдэг байх ёстой. Тэд усны хувцас заавал өмссөн байна. Туршилтад оролцогч тус бүрд туршилтын үе шат бүрийг танилцуулж, ялангуяа доошоо харж буй байрлалд тайван байх, зөв амьсгалахад тавигдах шаардлагын талаар зөвлөнө.

Туршилтад оролцогч нь хөвүүлэгч хэрэгслийг бусдын туслалцаагүй, зөвхөн үйлдвэрлэгчийн зааврыг ашиглан өмсөнө. Оролцогч тус бүрийн усанд хөвөгч тавцан нь ISO 12402-9:2006 стандартын 5.6.2-т заасан хэмжээтэй байх ба эерэг

байна.

5.6.3.2 Хөвүүлэгч хэрэгслийн хэвийн ажиллагаатай нөхцөлд ISO 12402-9:2006 стандартын 5.6-д заасны дагуу туршилт хийхэд уг хэрэгсэл оролцогчыг 5.6.3.1-д шаардсан байрлалд 5 секундын дотор эргүүлж оруулна.

5.7 Олон тасалгаат хөвүүлэгч систем

Олон тасалгаат хөвүүлэгч систем нь, түүний дурын аль нэг тасалгаа хийгүй болсон байсан ч ISO12402 стандартын энэхүү хэсэгт заасан ашиглалтын шаардлагыг хангаж байх ёстой. Олон тасалгаат хөвүүлэгч систем нь ISO 12402-8:2006 стандартын 5.7-д заасантай нийцсэн байна.

6. Тэмдэглэгээ

6.1 Ерөнхий зүйл

Хөвүүлэгч хэрэгсэл дээр 6.2-т заасан мэдээллийг маш тод, арилахгүйгээр тэмдэглэсэн байх ба уг мэдээллийг хүлээн авах улс орны албан ёсны хэлээр өгсөн байна. Мэдээллийг дүрс зургаар, эсвэл дүрс зураг ба эх бичвэрийг хослуулах, хэрэв тодорхой дүрс зураг байхгүй бол зөвхөн эх бичвэрээр өгсөн байна.

6.2 Хөвүүлэгч хэрэгсэл дээрх мэдээлэл

Хөвүүлэгч хэрэгсэл дээрх мэдээлэл нь дор дурдах зүйлсийг агуулна:

- a) үйлдвэрлэгчийг таних, тогтоох – Үйлдвэрлэгчийн, эсвэл төлөөлөгчийн нэр болон тэдгээрийн цахим хаяг;
- b) ХХХ-ийн ангилал ба 4.2 заалтад нийцсэн ашиглалтын түвшин;
- c) бүрэн хэмжээгээр хийлээгүй бол ХХХ биш гэсэн анхааруулга (зөвхөн бүрэн хийлэгдсэн ХХХ);
- d) хөвүүлэгч хэрэгслийн хэмжээ /размер/-ний жагсаалт, жишээ нь: цээж хэвлийн тойргийн хэмжээний ба хэрэглэгчийн биеийн массын жагсаалт;
- e) хөвөх чадварын хамгийн бага хэмжээ болон хэрэв хосолмол ажиллагаатай төрлийнх бол хийлэгддэг хөвөх чадварын нийлбэр;
- f) хадгалалт, арчилгаа, цэвэрлэгээ, засвар үйлчилгээний товч зааварчилгаа;
- g) энгийн өмсөх ба тохируулах заавар;
- h) ашиглах энгийн заавар;
- i) газар хийлдэг бол, цилиндрийн зөв хэмжээ ба цэнэг;
ТАЙЛБАР: Энэ мэдээлэл нь цилиндрийг ихэнхдээ суурилуулдаг газрын ойролцоо байна.
- j) газар хийлдэг бол хийн цилиндр нь аюултай бараа болохыг сануулж, тэдгээрийг хүүхдээс холдуулж, буруугаар ашиглахгүй байхыг анхааруулах;
- k) үйлдвэрлэгчийн загвар, таних тэмдэг, серийн дугаар, үйлдвэрлэсэн он ба улирал (эсвэл сар);
ТАЙЛБАР: Саруудыг араб тоо (1-ээс 12)-гоор, улиралыг Ром тоо (I-IV)-гоор илэрхийлж, 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тоолно.
- l) ISO 12402 стандартын энэхүү хэсгийн дугаар;
- m) ашиглалтын явцад урьдчилан мэдэх боломжгүй бусад эрсдэлийг харуулсан дүрс зураг буюу үгс;
- n) "Зөөлөвч болгож бүү ашигла" гэсэн сануулга бичвэр;
- o) "Хэрэгслийг ашиглахад өөрөө суралцах" гэсэн эх бичвэр;
- p) хүүхдэд зориулагдсан бол "энэхүү хөвүүлэгч хэрэгсэл дээр хөвөхийг хүүхдэд заах" гэсэн эх бичвэр;

MNS ISO 12402-5 : 2017

- q) хүүхдэд зориулагдсан бол "6-аас доош насны хүүхдүүдэд зөвхөн автомат ажиллагаатай хөвүүлэгч хэрэгслийг ашиглах" гэсэн эх бичвэр;
- r) түүний тусгайлсан хэрэглээний хүрээ;
- s) дундаж эдэлгээний үед үзүүлэх хүлээгдэж буй үйлчилгээний давтамж болон түүний дотор нэмэлт дагалдах хэрэгслүүд (газын сав, хөвүүр, гэрэл ойлгогч тууз г.м) -эд үйлчилгээ, засвар хийх, солих огноо, хугацааг тэмдэглэсэн байна;
- t) хувцас болон холбогдох нэмэлт тоног төхөөрөмж нь аюулгүй байдлын хамгаалалтын бэхлэгцэтэй тохирч нийцэж байх;
- u) "Усны хамгаалалттай хувцасны тусламжтайгаар эсвэл бусад нөхцөл байдалд бүрэн ашиглалтанд хүрэхгүй. Мэдээлэх хуудаснаас лавлана уу" гэсэн эх бичвэр;
- v) "Анхааруулга: Хөвүүлэгч хэрэгслийг ашиглахдаа хөвөгч живх хэрэглэж болохгүй" гэсэн эх бичвэр;

ТАЙЛБАР: Энэхүү анхааруулга нь хөвүүлэгч хэрэгслийг ашиглах 15 кг хүртэлх биеийн жинтэй хэрэглэгчдэд тавигдах шаардлага юм.

Энэхүү мэдээллийг агуулсан шошгыг хөвүүлэгч хэрэгсэлд хуулагдахааргүй бат бөх бэхлэх бөгөөд давстай усанд, мөн үйлдвэрлэгчийн зааврын дагуу 10-аас доошгүй удаа угаахад тэсвэртэй байна. Угаасны дараа шошгоны агшилт 10%-иас хэтрэхгүй байна.

"Нэхмэл тор" тусгай дүрс зураг нь нэхмэлийн бөөрөнхий утсаар туузан (нарийн даавуу) тор нэхэх болон "үхрийн сүүл" бэхлэгцээг хэрхэн хослуулах талаарх үйлдвэрлэгчийн нарийн тодорхой зөвлөмжийг харуулж буй ба "энэхүү хэрэгслийг ашиглахын өмнө бэлтгэл, дадлага хийх шаардлагатай" гэсэн эх бичвэрийг хөвүүлэгч хэрэгслийн дээр байрлуулж, мөнхүү мэдээллийг түүнд дагалдуулна.

7. Үйлдвэрлэгчээс өгсөн мэдээлэл

Хөвүүлэгч хэрэгслийг доод тал нь дараах зүйлсийг агуулсан тайлбар бүхий гарын авлагаар хангасан байна:

- a) 6.2-т дурдсан зүйлс;
- b) хэрэглэгч, хөвүүлэгч хэрэгслийг хэрэглэхийн өмнө ашиглаж болох, эсэхийг тогтоох талаарх зөвлөмж;
- c) өмсөх, хэрэглэхэд зориулсан бүрэн заавар (хэрэв тоноглогсон бол шүгэл, гэрэл хэрэглэх зааварчилгаа мөн дагалдана);
- d) хэрэглэх үед санамж болгон зөвлөж буй хязгаарлалт, түүний дотор далай, тэнгисийн нөхцөл, температурын хязгаар, эдэлгээний хугацаа болон бусад зохих ёсны дэлгэрэнгүй мэдээлэл;
- e) дурын эд анги, сэлбэг хэрэгслийн тодорхойлолт, тэдгээрийг солих, засвар, үйлчилгээ хийх, ашиглах талаарх зааварчилгаа болон хэрэв хэрэглэх бол баглаа боодлын зааварчилгаа байна;
- f) аврах хантаазны арчилгаа, хэрэглээнд тавих анхаарал халамжийн талаар үйлдвэрлэгчийн хэрэгцээтэй гэж үзсэн бусад ерөнхий зөвлөгөө.

8. Борлуулалтын цэг дээр хэрэглэгчид өгөх мэдээлэл

8.1 Ерөнхий зүйл

Хэрэглэгчид мэдээллийг энгийн эх бичвэр хувилбар (Хүснэгт.1 ба 2-г харах)-аар,

эсвэл дүрс зурган хувилбараар (Хүснэгт.3-г харах) өгнө.

8.2 Энгийн эх бичвэр

Хөвүүлэгч хэрэгслийг худалдаалахад бэлтгэх үед мэдээлэл нь ил тод, гаргацтай, ойлгомжтой байх ба эсвэл аврах хантааз дээр тод өнгийн тэмдэглэгээ өөрөө хийх замаар, эсвэл баглаа боодол дээр нь нэмэлт шошго хийж худалдаанд гаргана.

Хэрэв мэдээлэл нь өөр өөр хэсгүүдэд хуваагдсан байвал, тэдгээр бүх хэсгүүдийг хамтатган харахад дөхөм (XXX-системийг бүхэлд нь хянасан) байдлаар хэрэглэгчид өгнө. 1 ба 2-р хүснэгтэд шошгоны өгөгдсөн байршлыг зөвлөмж болгож байгаа бөгөөд харин агуулга нь өөрчлөгдөхгүй.

Хэрэв энгийн эх бичвэр хувилбарыг сонгосон бол мэдээллийг 1-р хүснэгтэд заасны дагуу байршуулна. Мэдээлэл нь хамгийн багадаа 75ммx75мм хэмжээтэй байх ёстой. Эх бичвэр болон шошгоны өнгө нь өөр өөр байж болох боловч дэвсгэр өнгөнөөсөө үргэлж ялгаатай байна.

ТАЙЛБАР 1: хүснэгтийн (8)-дахь мөрд тусгагдсан мэдээллийг энгийн эх бичвэр өгөгдлүүдээр, эсвэл нийлүүлэгчийн барааны тэмдгийн төлөөллөөр илэрхийлэх боломжтой.

ТАЙЛБАР 2: Хүснэгт.1-д үзүүлсэн шошго нь иж бүрэн шошгоны зүүн талыг бүрдүүлэх ба өгөгдлийн жагсаалтаас урьдчилан тохирсон бүх өгөгдлийг төлөөлнө. (2-р хүснэгтээс үзнэ үү.)

2-р хүснэгтэд үзүүлсэн шошгын баруун хэсгийн байршил нь нэмэлт байна. Агуулгыг өгөгдлийн жагсаалтаас үзнэ үү. Хүснэгтэд оруулсан бичилт нь жишээ юм.

Хувийн хөвөгч хэрэгсэл	ISO12402-2-оос ISO12402-6	(1)	
Хэрэглээ	Гүйцэтгэлийн түвшин	(2)	
Эргээс хол, онцгой хүнд нөхцөл, хамгаалалтын тусгай хувцас, хүнд тоног төхөөрөмж	Аврах хантааз	275	(3)
Эргээс хол, цаг агаарын таагүй нөхцөлд өмсөх хувцас		150	(4)
Хамгаалагдсан ус, тод өнгийн хувцас		100	(5)
Зөвхөн усанд сэлэгчид, хамгаалагдсан ус, гараар аврах, живэхээс аврах хязгаарлагдмал хамгаалалт, аврах хантаазгүй	Хөвүүлэгч хэрэгсэл	50	(6)
Тусгай зориулалтын хэрэгсэл	Гүйцэтгэлийн бүх түвшин		(7)
Үйлдвэрлэсэн:,			(8)
.....,			
АНХААРУУЛГА: ХӨВҮҮЛЭГЧ ХЭРЭГСЭЛ НЬ ЗӨВХӨН ЖИВЭХ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛНА, АВРАХ БАТАЛГАА ӨГӨХГҮЙ			(9)

1-р хүснэгт – Шошгоны тодорхойлолт

ТУСГАЙ ШИНЖ ЧАНАР		Ослын дохионы гэрлийг давалгааны хамгаалалт юүдэн малгайтай хослуулах					
ТУСГАЙЛСАН ХЭРЭГЛЭЭ		Уур амьсгалын онцгой хүнд нөхцөлд ашиглах (-50°C)					
АЖИЛЛАХ ГОРИМ		Загвар					
Автомат ажиллагаатай	гар ажиллагаатай	Зөвхөн амаар үлээж хийлдэг	Олон тасалгаат систем	Хийлдэг хөвөгчийн хэмжээ, (N)	Усанд өөрөө хөвөх чанар, (N)	Бэхлэгтэй хэрэглэх	
						Бэхлэгээ, уяа, оосорыг хослуулах	Тийм Үгүй
Гүйцэтгэл-ийн түвшин	275						
	Аврах ханта азууд	150					
	100						
Хөвүү лэгч хэрэг сэл					70		✓
Гүйцэтгэлийн бүх түвшин							
Үйлдвэрлэсэ н:.....							
АНХААРУУЛГА: ХӨВҮҮЛЭГЧ ХЭРЭГСЭЛ НЬ ЗӨВХӨН ЖИВЭХ ЭРСДЛИЙГ БУУРУУЛНА, АВРАХ БАТАЛГАА ӨГӨХГҮЙ	Хэмжээ	Цээж (см)	Биеийн жин (кг)	Тодорхой биеийн жинд зориулсан хөвөх чанар (N)	Бодит үнэлгээ	Нэрлэсэн үнэлгээ	
	Дундаж	70	70	70		50	

Хувийн хөвөгч хэрэгсэл	Хэрэглээ	Эргээс хол, онцгой хүнд нөхцөл, хамгаалалтын тусгай хувцас, хүнд тоног төхөөрөмж	Эргээс хол, цаг агаарын таагүй нөхцөлд өмсөх хувцас	Хамгаалагдсан ус, тод өнгийн хувцас	Зөвхөн усанд сэлэгчид, хамгаалагдсан ус, гараар аврах, жīvэхээс аврах хязгаарлагдмал хамгаалалт, аврах хантаазгүй	Тусгай зориулалтын хэрэгсэл		
------------------------	----------	--	---	-------------------------------------	---	-----------------------------	--	--

2-р хүснэгт - нэмэлт боломжууд болон сонгох шалгууруудыг агуулсан хэрэглэгчид мэдээлэл өгөх иж бүрэн шошго

8.3 Өгөгдлийн жагсаалт

Хэрэв зөвлөмж болгосон шошгоны загварыг хэрэглэхгүй бол дараах зүйлсийг, түүний дотор бүх хувьсах өгөгдлийг багтааж, хөвүүлэгч хэрэгслийн хэмжээ /размер/ болон ашиглалтын талаар хэрэглэгчдэд дэс дараатай мэдээлэл өгнө.

- a) ерөнхий нэр томъёо
- b) холбогдох стандарт, ашиглалтын түвшингийн тодорхойлолт;
- c) дурын тусгай онцлог үзүүлэлт, шинж чанар;

ТАЙЛБАР: Хэрэв хөвүүлэгч хэрэгсэл нь стандартад заасан ашиглалт, тоног төхөөрөмжөөс илүү нөхцөлийг, тухайлбал, давалгааны хамгаалалт малгайг аюул ослын тусгай тоноглол хэрэгсэлтэй хослуулах зэргийг шаардаж буй бол тусгай онцлог үзүүлэлт болно.

- d) дурын тусгай хавсралтууд;

ТАЙЛБАР: тусгай зориулалтаар, тухайлбал, байгаль, цаг уурын онцгой хүнд нөхцөлд ашиглах эсвэл гал сөнөөх болон уулын ширүүн урсгалт голын спортын тактикт хэрэглэх талаарх тодорхойлолт.

- e) хөвөх чанарыг хангаж буй эсэх
 - усанд хөвөгч материал,
 - хий /газ/ эсвэл агаар,
 - усанд хөвөгч материал болон газ эсвэл агаар;
- f) хөвүүлэгч хэрэгсэл нь: **эсэж**
 - бүрэн автомат ажиллагаатай,
 - гар ажиллагаатай,
 - зөвхөн амаар хийлдэг;
- g) хөвөх чанарын хэмжээ
 - нийтдээ,
 - усанд хөвөгч болон хийлдэг хөвөгч хэсгүүдийн хувьд;
- h) аюулгүй байдлын бэхэлгээтэй, эсэх
 - аврах хантаазанд хослуулсан,
 - дээрх хөвөгч хэрэгслийг биедээ өмсөх;
- i) хөвүүлэгч хэрэгслийн хэмжээ /размер/

MNS ISO 12402-5 : 2017

- хэмжээний хүснэгтээс тохирох хэмжээг тэмдэглэх,
- тухайн хүний холбогдох биеийн хэмжээ (биеийн өндөр, цээжний тойрог, биеийн жин эсвэл тэдгээрийг зохих ёсоор хослуулах)-г өгөх, Хүснэгт 2-т үзүүлсэн шошгоны баруун талыг харах.

ТАЙЛБАР: Жагсаалтад агуулагдсан бүх өгөгдлийг Хүснэгт 2-т үзүүлснээр, эсвэл өөр формат, байршлаар өгч болно.

Хэрэв 2-р хүснэгтэд үзүүлсэн зөвлөмж болгосон шошгыг хэрэглэсэн бол байгаа өгөгдлүүдийг тохиромжтой газар нь тэмдэглэж, тэдгээрийн тоог зохих хүснэгтэд оруулна.

8.4 Дүрс зураг

1-р хүснэгтийн 'Хэрэглээ' хэсгийн (2) -оос (6) мөрүүдийг 3-р хүснэгтэд үзүүлсэн холбогдох дүрс зургаар сольж болно. Эдгээр дүрс зургийн хэмжээ нь 50 мм х 50 мм-ээс багагүй байна. 1-р хүснэгтийн (1) ба (7) -аас (9) мөрүүдэд үлдсэн агуулгыг 8.3-т нийцүүлэн үзүүлнэ.

Холбогдох стандартын тэмдэглэгээ болон гүйцэтгэлийн түвшингийн утгыг дүрс зурагт оруулахад тухайн стандартыг хэвлэн нийтлүүлснээс хойшхи 5 жил нь танилцуулах, шилжүүлэх үе байж болно. Эх бичвэр нь 1-р хүснэгтийн (3)-аас (6) дахь мөрд томъёолсонтой ижил байна.

8.5 Өнгөний код

1-р хүснэгтэд үзүүлсэн шошгоны (3), (4), (5) ба (6) мөрүүдийн дэвсгэр өнгийг тодорхойлсон бөгөөд дүрс зурагт дүрсэлсэн байна. Хэрэв өнгөний код хэрэглэвэл нь дараах өнгүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- а) шошгоны (3) дахь мөр болон дүрс зураг '275' цэнхэр өнгөтэй байна;
- б) шошгоны (4) дэх мөр болон дүрс зураг '150' оюу ногоон өнгөтэй байна;
- в) шошгоны (5) дахь мөр болон дүрс зураг '100' цайвар бор өнгөтэй байна;
- д) шошгоны (6) дахь мөр болон дүрс зураг '50' ягаан өнгөтэй байна.

ТӨГСӨВ.

НОМ ЗҮЙ

- [1] ISO 12401, Бага оврын хөлөг онгоц – Тавцангийн аюулгүй байдлын бэхэлгээ болон хашлаганы аюулгүйн бүсийг аялал зугаалгын хөлөг онгоцонд хэрэглэх - Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага, турших арга барил
- [2] ISO 12401-1, Хувийн хөвөгч хэрэгсэл - 1-р хэсэг: Далайд аялах хөлөг онгоцон дээр хэрэглэх аврах хантааз — Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага;
- [3] ISO 12401-2, Хувийн хөвөгч хэрэгсэл - 2-р хэсэг: Аврах хантааз, гүйцэтгэлийн түвшин 275 — Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага;
- [4] ISO 12401-3, Хувийн хөвөгч хэрэгсэл - 3-р хэсэг: Аврах хантааз, гүйцэтгэлийн түвшин 150 — Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага;
- [5] ISO 12401-4, Хувийн хөвөгч хэрэгсэл - 4-р хэсэг: Аврах хантааз, гүйцэтгэлийн түвшин 100 - Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага;
- [6] ISO 12401-6, Хувийн хөвөгч хэрэгсэл - 6-р хэсэг: Тусгай зориулалтын аврах хантааз ба хөвүүлэгч хэрэгсэл — Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага ба турших, шалгах арга;
- [7] ISO 12401-10, Хувийн хөвөгч хэрэгсэл - 10-р хэсэг: – Хувийн хөвөгч хэрэгсэл болон бусад дагалдах хэрэгслийг сонгон хэрэглэх.
- [8] “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” олон улсын конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан (SOLAS), 1974 он, Олон улсын далайн байгууллага⁵⁾.